



ХҮҮХДИЙН БҮТЭЭЛИЙГ ХАДНЫ ЗУРАГ ДҮРСЛЭЛТЭЙ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

Н. Хүдэрчулуун^а, Ц.Золзаяа^б

^аМУБИС-Багшийн сургууль, багш магистр;

^бМУБИС-Сургуулийн өмнөх боловсролын сургууль, багш, доктор

Холбоо барих зохиогч: khuderchuluun@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Хүүхдийн зураг бол дүрслэл бэлгэдлийн сэтгэлгээний бүтээгдэхүүн бөгөөд бага насны хүүхдийн зурсан зургийг эртний хүний сэтгэхүй зураг дүрслэлтэй харьцуулж үзэхэд олон талаар төсөөтэй зүйл байдгийг энэхүү судалгааны ажлаараа харуулахыг зорилоо.

Түлхүүр үг

Сараачлага, бүдүүвч, бодит, хийсвэр дүрслэл.

Удиртгал

Эртний хүмүүсийн зураг дүрслэл нь хүүхдийн зурсан зурагтай олон талаараа ижил төстэй байдгийг цөөнгүй эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Үүнээс нэн эртний чулуун зэвсгийн үеийн хадны сүг зураг болон агуйн хана туурганы зосон зургийг судалсан эрдэмтэд тэр үеийн хүний ертөнцийг үзэх үзэл сэтгэлгээ нь хүүхдийн сэтгэхүйтэй адил байжээ гэсэн дүгнэлтэд хүрснийг онцлон тэмдэглэжээ (Бадрал.С, 2011).

Хүүхдийн зурах үйлийн судалгаа нь эхэн үедээ импирик буюу туршилтын шинжтэй байснаа дараа нь хүүхдийн зураг дүрслэлийг сэтгэл судлалын талаас нь голлон судлах болсон бөгөөд биологи, урлаг судлал болон гештальт сэтгэл зүй, фрейдизмийн үүднээс тайлбарлагдах болжээ. Хүүхдийн зураг дүрслэлийн судалгааг дараах эрдэмтэн судлаачид болох эмч, сэтгэл судлаач К.Риччи (1850), В.Пейера (1894), Кершенштейнара (1914), Ж.Селли (1904), К.Бюллера (1924), Ж.Пиаже, Л.С.Выготский, В.Ловенфилд. Вэтти Эдвардс, Н.П.Сакулина, В.С.Мухина, Д.С.Казаков нарын эрдэмтэд энэ талын судалгааг голлон хийсэн байдаг.


XX зууны эхээр үүссэн Э.Геккелийн онтогенез нь филогенезийн богино бөгөөд хурдан давталт болох тухай биогенетикийн онол нь хүүхдийн сэтгэл зүй болон сурган хүмүүжүүлэх ухааны тухай ерөнхий онол болж хувирсан.

Урлаг судлаачид хүүхдийн зургийг уран бүтээл болох нь гэх үүднээс өнгө, дүрслэл, зохиомж, гоо зүйн талаас нь, харин биологийн талаас нь дээд ангилалын бичний үйлдэлтэй харьцуулан судалсан байдаг. Тэгвэл багш сурган хүмүүжүүлэгчид

боловсрол судлалын үүднээс зурах үйл ажиллагааны агуулга, арга зүйн хөгжил, хүүхдийн зурах авьяас, чадварыг дэмжихэд чиглэсэн судалгаа хийдэг бол сэтгэл судлаачид хүүхдийн зурсан зураг дах тэдний дотоод сэтгэлийн өвөрмөц ертөнцөд нэвтрэн орох боломжийг тус тус судалсан байна. Хүүхдийн зурж дүрслэх үйлийн хөгжлийн үечлэл бол хүүхдийн зурах чадварыг тодорхойлох хэм хэмжээ бүхий нэгдмэл тогтолцоо юм.

Судлаач О.Нацагдорж хүүхдийн зурж дүрслэх үйлийн онцлог, хөгжлийн үе шатыг дараах байдлаар тодорхойлжээ.

Зураг 1. Хүүхдийн зурж дүрслэх үйлийн онцлог



Сараачлага дүрслэлийн үе /1-3 нас/ Хүүхдүүд заримдаа харандаагаа багаж болгон барьж өөр зүйл рүү харж байгаад ухамсарлахгүйгээр эрээчиж сараачих үйлдэл хийдэг. Оросын эрдэмтэн В.С.Мухина өөрийн бүтээлдээ “Сармагчин хүртэл хүнийг дуурайн харандаа барьж зурдас хийдэг” Энэхүү “сараачлага” зураас нь зурж дүрслэх үйл ажиллагааны эхлэл үе болдог гэж тайлбарласан (Мухина.В.С, 1981).

Бүдүүвч дүрслэлийн үе (3-5 нас) Эртний хүмүүс хүн амьтныг зурахдаа МЭӨ III-II зууны үед дэлгэрсэн ”араг яс” гэх хэв маягийн нарийн зураасаар биеийн хэлбэрийг нарийвчлан тоочилгүй, хөдөлгөөн дүр төрхийг хамгийн оновчтойгоор бүдүүвчлэн зурдаг байжээ. Үүнтэй төстэй дүрслэл ойролцоогоор 3-5 настай хүүхдэд илрэх бөгөөд энэ нь зурж дүрслэх үйл ажиллагааны хөгжилд шинэ үе шатыг эхлүүлдэг. Энэ нь хүүхдийн зургийн “Алтан үе” буюу бүдүүвч дүрслэлийн үе юм.

В.В.Селливановын судалгаагаар эртний хүмүүс болон бага насны хүүхдийн зурсан зургуудыг хооронд нь харьцуулж үзээд эртний хүмүүсийн зурсан хадны зурагт амьтаны дүрслэл зонхилдог бол харин хүүхдийн зурах дуртай зүйл нь хүн байдгийг тогтоожээ.

Бодит дүрслэлийн үе (6-11 нас). Бүдүүвч дүрслэлийн үед хүүхдийн зурсан зургийн хэлбэр харьцаа сайжирч хүн амьтан, эд зүйлийн ерөнхий хэлбэр, байгуулалт зөв болсноор бүрдүүлэгч элементүүдийн хоорондын холбоо хамаарал зохистой болно (Мэндээ.Г, Батчулуун.С, Нацагдорж.О, 2011). Энэ үед хүүхэд өөрийн бодол төсөөлөл мэдрэмжээ зураг бүтээлээрээ илэрхийлэх боломж бүрддэг.

Хийсвэр дүрслэлийн үе (11-15). Энэ үед хүүхдийн хүсэл сонирхол, сэтгэлгээний хүрээнд ахиц гарснаар дүрслэх үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарч зураг дүрслэл нь сэтгэлгээний чиг хандлагатай болж ирдэг. Зургийн зохиомж, алслалт, харьцаа, өнгө, гэрэл, сүүдэр зэрэг дүрслэлийн гол хуулиудыг судалж бие дааж

бүтээл хийх түвшинд хүрсэн байдаг.


Хадны зураг дүрслэл нь өнөө үед хүүхдийн бүтээлд тусгалаа олсон байдаг нь биогенетикийн онол, үзэл бариматлалтай холбоотой болох нь харагдаж байна. Хүн төрөлхтний бүтээсэн оньсон хөдөлгүүрийн хамгийн чухал ололтын нэг бол дугуйт хөсөг тэрэг юм. Судлаач Б.Гончигдорж “Хүрлийн үеийн хүний дүрслэл тэрэгний дүрслэл бол хүний ойлгож төсөөлөх процессыг нэг дор нэгтгэн хавтгайд жишиж, төсөөлж буулгасан дүрслэл юм” гэж тодорхойлсон байдаг. Үүнээс үзэхэд монгол зургийн уламжлалт арга ажиллагаа болох хөдөлгөөнтэй олон харааны цэгээс дүрслэх аргын эхлэл нь хүрлийн үед тавигдсанаар хийсвэр дүрслэлийн үе эхэлжээ.

Зураг 2. Эртний зураг дүрслэлийг хүүхдийн бүтээлтэй харьцуулсан судалгаа




Судлаач Д.Дашхүү Монгол хүүхдийн анхны зураг дүрслэл нь бусад орны хүүхдийн нэгэн адилаар ”сараачлага” маягийн дүрслэл хийж эхэлдгийг баталсан (Дашхүү,Д, 2001). Цаашид зураас нь эмх цэгцтэй зорилго чиглэлтэй болж ирдгийг доорх зураг 3,4 үзүүлэв.


Зураг 3.



Шинпанзе сармагчны зурсан зурдас



Х.Андрей нас 2



“Захидал”
Н.Болор нас 3




“Шуурга”
Б.Мөнхжин нас 3


Зураг 4.



Өлзийтийн хадны зургаас



Г.Мэндбаяр “Гол дээр”




М.Уянга “Хашаан дотор”



Спортын төрлүүдээс

Энэхүү бүдүүвч зургийн аргыг өнөө цагт дүрслэх урлагийн сургалтад уламжлан хэрэглэсээр байна.

Зураг 5. Хүн амьтны хөдөлгөөнийг бүдүүвч байдлаар загварчилсан дүрслэл



Судлаач С.Батчулуун “Эртний хүмүүсийн сэтгэхүйн анхны илэрхийлэл нь бодит дүрслэл байдаг. Эртний хүний сэтгэлгээний дараагийн шатанд сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх үйлд тодорхой өөрчлөлт гарч, тэр нь хүртэгдэн байгаа юмс үзэгдлийн бодит шинжээс аажмаар салж, сэтгэхүйн хийсвэр төсөөлөл бүрэлдэн тогтож эхэлсэн байдаг” (Батчулуун.С, 2011) гэж бодит болон хийсвэр дүрслэлийн үеүүдийг тодорхойлсон.

Зураг 6. Эртний зураг дүрслэл болон хүүхдийн бүтээлийн адил төсөөтэй талууд



Ховд хойд цэнхэрийн агуйн сүг зураг

Н.Хүдэрчулуун “Адуучин аав”


Б.Мөнхжин “Ойдоо эргэж очих юмсан”

Н.Баатархүү “Хашаатай хонь ямаа”


Хажуу талаас давхарлан дүрсэлсэн дүрслэлийг түүхийн ухааны доктор Н.Сэр-Оджав “Эртний урчууд хадны зураг сийлэхдээ гол төлөв хажуугаас харсан байдлаар урладаг тул амьтан хүний хөлийг хүртэл давхарлан байгаа байдлаар дүрсэлсэн байна” (Сэр-Оджав.Н, 1987) гэж тэмдэглэсэн байдаг.

Зураг 7.

Эгц дээрээс харсан зургууд



Дөрвөн талаас харсан зургууд



Х.Энэрлэн
"Цангасан үхрүүд"




Э.Насалмаа "Сурын харваа" Дээрээс, араас, хажуугаас, урдаас харсан байдал




Хадны сүг зураг бол хүй нэгдлийн урлагийн дурсгал юм. Тэр үеийн хүмүүс адгуус амьтдыг хажуу талаас нь, хүнийг эгц урдаас нь зурсан байдаг (Майдар.Д, 1982). Хүн амьтны энэхүү дүрслэлийг дээрх хүүхдийн зургуудаас харж болно. Түүнчлэн хүүхэд зохиомжийн хувьд нэвт харагдах байдлаар зурдгийг судлаач К.Бюллер анхлан тогтоожээ.” БНХАУ-ын Алшаа аймгийн нутаг дахь Мандал уулын хадны зурагт эхийн хэвлийд буй хүүхэд, урцанд байгаа хүмүүсийг нэвт харагдах байдлаар дүрсэлсэн байдаг. Энэхүү дүрслэл нь хүүхдийн зурсан зурагт элбэг тохиолддогийг доорх зургаас харж болно.



Зураг 8. Хадны сүг зурагтай харьцуулсан дүрслэл



Мандал уулын хадны зураг



Ц.Мөнхжин "Гэртээ"



Х.Энэрлэн "Хөршийндөө Очив"


Дэлгэмэл зохиомжтой ижил төстэй дүрслэл хадны сүг зурагт цөөнгүй тохиолддог. Үнийг судлаачид “Эртний хүмүүс зурсан амьтнаа олон дахин давтан зурахын оронд сүрэг амьтныг толбоор төлөөлүүлэн үздэг нь палентлогийн үеийн дүрслэх урлагийн бас нэгэн онцгой шинж” (Цэвээндорж.Д, 1999) гэж тэмдэглэжээ. Хүүхдэд

дэлгэмэл зохиомжоор зурахдаа давтамжтай зураасаар, ижил дүрсээр зохиомжлон дүрсэлдэг нь доорх зургуудаас тодорхой харагдаж байна.

Зураг 9. Дэлгэмэл зохиомжтой ижил төстэй дүрслэл




Хадны зураг



Х.Цэрэндорж “Хөвсгөл нутаг”



Б.Мөнхжин “Сумогийн барилдаан”



Зураг 10. Хүүхдийн бүтээлд эртний зураг дүрслэл өвөрмөцөөр туссан байдал

Дээрх янгирын зургаас үзэхэд ижил төстэй дүрслэл цөөнгүй давтагддагыг харж болно. Үүнд:

- Янгирын хөдөлгөөн нь хүннүгийн үеийн ширдэгний зурагтай
- Янгирын толгой нь хүрлийн үеийн хүрэл илдийн дүрстэй
- Эргэж харсан янгир нь хүй нэгдлийн үеийн хадны зураг дүрслэлтэй төсөөтэй болохыг харж болно.


Судалгааны үр дүн

Судалгаанд аймаг хот, хөдөө орон нутгийн 2-15 насны хүүхдүүдийн төв орон нутгийн хэвлэл, ном сэтгүүл, сурах бичгүүдэд нийтлэгдсэн 475 бүтээлд дүрслэгдсэн, хүн амьтны 2370 зураг дүрслэлд судалгаа хийлээ.

Эртний хадны зураг болон хүүхдийн зургууд нь ихэвчлэн энгийн, схемчилсэн дүрслэлтэй төсөөтэй байсан бөгөөд шугаман дүрслэл, цэгэн арга, хавтгай дүрслэл зэрэг зохиомжийн техникүүд эртний зураг болон хүүхдийн бүтээлд түгээмэл ажиглагдлаа.

Диаграмм 1. Хүүхдийн бүтээлд хүн, амьтныг дүрслэсэн нь
Судалгаанд дүрслэгдсэн хүн 1375

■ Хажуугаас ■ Эгц урдаас ■ Араас ■ дээрээс




Нийт судалгаанд хамрагдсан бүтээлүүдэд хүнийг эгц урдаас 44%, хажуугаас 34%, араас 18%, дээрээс 4% нь дүрсэлжээ. Энэ зураглалаас дүгнэн харвал эгц монгол хүүхдийн дүрийн дийлэнх хувь нь эгц урдаас дүрслэгдсэн байдаг нь харагдаж байна.

Диаграмм-2

Судалгаанд дүрслэгдсэн амьтан 1005

■ Хажуугаас ■ Эгц урдаас ■ Араас ■ дээрээс



Нийт судалгаанд хамрагдсан бүтээлүүдэд дүрслэгдсэн амьтадыг эгц урдаас 25%, хажуугаас 52%, араас 8%, дээрээс 15% нь дүрсэлжээ. Энэ нь амьтныг дүрслэхдээ эгц урдаас дүрсэлсэн нь хадны зургийн үед үүссэн дүрийн сэтгэлгээг илэрхийлж байна.

Дүгнэлт

Бага насны хүүхдийн зурж дүрслэх үйл нь санамсаргүйгээр сараачлага, зураас зурахаас эхэлдэг бөгөөд эртний хүмүүсийн зурж дүрсэлж байсантай төсөөтэй бүдүүвчлэх, бодит болон хийсвэрлэн дүрслэх үе шатуудыг дамжин хөгждөг. Мөн хүүхдийн дүрслэн зурах үйл ажиллагааны хөгжил нь өвөг дээдсийнхээ генийг өвлөн төрж, хүний нийгмийн хөгжлийн анхны үе болох хүй нэгдлийн нийгмээс өнөөг хүртлэх хугацааны хөгжлийг ердөө 12 хүртэлх насандаа дамжин өнгөрдөг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Бага насны хүүхдийн дүрслэх сэтгэхүйн онцлог арга барил нь харааны олон цэгийг хослуулан дээрээс харсан, эсвэл эгц хажуугаас харсан хоёр хэмжээст дүрслэлээр зохиомжийг илэрхийлэн зурж дүрсэлдэг уламжлалт зураг дүрслэлийн аргатай олон талаар адил байна (Дашдаваа.Ж, 1999) гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Нийт судалгаанд хамрагдсан бүтээлүүдэд хүнийг эгц урдаас 44%, хажуугаас 34%, араас 18%, дээрээс 4% нь дүрсэлсэн нь монгол хүүхдийн дүрийн дийлэнх хувь нь эгц урдаас зурдаг нь харагдаж байна. Харин амьтадыг дүрслэхдээ эгц урдаас 25%, хажуугаас 52%, араас 8%, дээрээс 15% нь дүрсэлсэн нь хүүхдүүд амьтныг зурахдаа дийлэнх хувь нь хажуугаас зурдаг нь харагдаж байна.

Хүүхдийн бүтээл болон эртний хадны зургийн харьцуулсан судалгаа нь хүний танин мэдэхүйн хөгжил, урлагийн илэрхийллийн үндсэн зарчмуудын талаар чухал ойлголтыг өгдөг. Хоёр төрлийн бүтээл нь энгийн дүрслэл, ертөнцийг хялбаршуулан ойлгох байдал зэрэг олон талаар төстэй байна. Гэвч тэдгээрийн зорилго, нийгэм соёлын нөлөө, хөгжлийн үе шат зэрэгт ялгаа ажиглагдаж байна. Цаашид энэ чиглэлээр илүү нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай бөгөөд энэ нь хүний оюун санаа, бүтээлч сэтгэлгээний үндсэн зарчмуудыг илүү гүнзгий ойлгоход тусална.

Судалгааны үр дүнгээс монгол хүүхдүүд зөвхөн хоёр талаас биш дээрээс, урдаас, араас, хажуугаас гэсэн дөрвөн талаас нь дүрсэлж чаддаг онцлогтой гэсэн дүгнэлтийг хийж байна.

Ном зүй

Бадрал.С. (2011). Чингис хаан, Монгол түүх урлагийн өв судлал. Улаанбаатар.

Батбаяр.Д. (2010). Зургийн авъяас. Улаанбаатар.

Батчулуун.С. (2011). Нүүдэлчдийн урлаг соёлын жимээр мөшгөхүй. Улаанбаатар.

Гончигдорж.Б. (1978). Эртний монголын шугам зураг. Улаанбаатар.

Дашдаваа.Ж. (1999). ЕБС-ийн дүрслэх урлагийн сургалтанд "Монголын уламжлалт зураг дүрслэлийг хэрэглэх нь". Улаанбаатар.

Дашхүү.Д. (2001). Сургуулийн өмнөх насны Монгол хүүхдийн зурж дүрслэх үйл ажиллагааны онцлогийг судалсан нь. Улаанбаатар.

Майдар.Д. (1982). Монголын түүх соёлын үнэт зүйлс. Улаанбаатар.

Мухина.В.С. (1981). Изобразительная деятельность ребенка как форма усвоения социального опыта. Москва.

Мэндээ.Г, Батчулуун.С, Нацагдорж.О. (2011). Дүрслэх урлагийн боловсрол. Улаанбаатар.

Сэр-Оджав.Н. (1987). Монголын эртний түүх. Улаанбаатар.

Цэвээндорж.Д. (1999). Монголын эртний урлал. Улаанбаатар.